**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Есөнбулаг сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ГАА-2026/002/НА-СТА-ТТЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2026 он | Дарга,Тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа<br>Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn<br>Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг<br>Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Д.Цэрэнханд<br>Утас: 99086371 Цахим хаяг: Tserenkhandd@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ....3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ....4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА....9
3.4.1 Мөнгөн хөрөнгө....11
3.4.2 Авлага....11
3.4.4 Бараа материал....12
3.4.5 Бусад эргэлтийн хөрөнгө....13
3.4.6 Үндсэн хөрөнгө....13
3.4.6 Өр төлбөр....14
3.4.7 Засгийн газрын хувь оролцоо....14
4. АУДИТЫН ТАЙЛАН....16
4.1 Ерөнхий зүйл....16
4.2 Материаллаг байдал....16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт....17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал....17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт....17
5.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ....18
5.1.1 Харьяа байгууллагууд....18
5.2 Төсвийн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт....19
5.3 Төлбөрийн акт....19
5.4 Албан шаардлага....19
5.5 Зөвлөмж....20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ....22

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| ААТҮГ | Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| ХХС | Хоршоо хөгжүүлэх сан |
| БХНСС | Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2026. 03. 24 № 143

танай ______________ -ны № ______________ -т

ЕСӨНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Н.ЗОЛЖАРГАЛ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Есөнбулаг сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доор зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Сумын Засаг даргын захирамжаар бараа үйлчилгээний бусад зардал, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас сар шинийн золголтод 10.3 сая төгрөг, уралдаан тэмцээний шагналд 33.9 сая төгрөг, бэлэг дурсгалын зүйлд 21.9 сая төгрөг, төсөвт байгууллагуудад 22.0 сая төгрөгийн дэмжлэг, аймгийн өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 3.0 сая төгрөгийн дэмжлэг, зорилтот бүлгийн иргэдэд нүүрсний дэмжлэг олгоход 9.5 сая төгрөг, өдөр өнжүүлэх төвд 10.0 сая төгрөг, сургалт туршлага судлах мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагаа санхүүжүүлэхэд 29.1 сая төгрөг, контент бичлэг хийхэд 3.6 сая төгрөг зэрэг үр ашиггүй тэвчиж болох зардлыг санхүүжүүлсэн,

822511000427

- Сумын Засаг даргын захирамжаар бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас спортын арга хэмжээний хувцас бэлтгэхэд 4.6 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан,
- Сумын Засаг даргын захирамжаар залуу малчин өрхийг малжуулах хөтөлбөрийн хүрээнд 3 өрхийг 12.0 сая төгрөгөөр малжуулахдаа буцаан авах нөхцөлгүй олгосон ба хөрөнгө хүлээлцсэн актгүй, анхан шатны баримт дутуу,
- Сумын орон нутгийн төсвөөс Засаг даргын Тамгын газарт 92.6 сая төгрөгийг илүү, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд 82.8 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон,
- Малын тоо толгойн албан татварын орлого 58.6 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлээгүй,
- Төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2,069.3 сая төгрөгийн зөрчил илэрснээс 8.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх 1,508.9 сая төгрөгийн 4 албан шаардлага, 299.5 сая төгрөгийн 12 зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлж, 252.4 сая төгрөгийн зөрчилд 4 албан тушаалтанд сахилгын хариуцлага тооцох албан шаардлагыг хүргүүлсэн,
- Төрийн аудитын байгууллагаас 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар өгсөн 01/174 дугаартай 1 албан шаардлага, 2022-2025 оны гүйцэтгэл, нийцлийн аудитаар өгсөн 438.6 сая төгрөгийн 11 албан шаардлагын биелэлтийг иргүүлээгүй, хэрэгжүүлэх арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.6, 16.5.7, 41 дүгээр зүйлийн 41.1, 41.2.5, 41.2.7 дахь заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 13 дугаар тогтоолоор 18,005.8 сая төгрөгийн татварын болон татварын бус орлогыг бүрдүүлэхээр баталж, гүйцэтгэлээр 18,908.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөөг 105.0 хувиар давуулан биелүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмаар шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг олгох бүрэн эрхийг Засаг даргад олгосон боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулиар дээрх арга хэмжээний зардлыг зарцуулахыг хориглосон байна.

Есөнбулаг сумаас аймгийн төсөвт 8,972.6 сая төгрөг төвлөрүүлсэн нь өмнөх оноос 2 дахин өссөн бөгөөд тус сумын ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгүүд нь 633.9 сая төгрөгийн тогтмол зардлын өр төлбөртэй гарсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд 1 хөтөлбөр, 2 зорилт, 223 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 96.3 хувьтай үнэлсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Г.ГҮНЖИДМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан (мянган төгрөг)

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

| Код | Тайлангийн үзүүлэлт | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **4,549,154.6** | **5,997,638.5** |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 1,305,393.4 | 2,802,678.0 |
| 33 | АВЛАГА | 1,288,161.6 | 1,171,342.0 |
| 34 | УРЬДЧИЛГАА | 1,864.2 | 37.4 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 374,551.4 | 279,903.1 |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | 44,596.0 | 81,952.0 |
| 360 | БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ | 1,554,895.3 | 1,661,726.0 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 11,132,550.4 | 15,596,457.8 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 11,132,550.4 | 15,596,457.8 |
| 39200 | Биет хөрөнгө | 10,809,464.6 | 15,255,086.8 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 323,085.8 | 341,371.1 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **15,702,012.3** | **21,594,096.3** |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 320,157.9 | 1,061,226.5 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 320,157.9 | 1,061,226.5 |
| 41300 | Өглөг | 320,157.9 | 1,061,226.5 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 15,381,854.4 | 20,532,869.8 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 15,381,854.4 | 20,532,869.8 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 5,003,083.5 | 5,003,083.5 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 8,302,379.0 | 13,464,805.6 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,076,391.9 | 2,064,980.8 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **15,702,012.3** | **21,594,096.3** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан (мянган төгрөг)

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

| Код | Тайлангийн үзүүлэлт | 2024оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **20,357,045.4** | **44,360,235.6** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **14,635,633.4** | **18,489,147.7** |
| 110 | Орлогын албан татвар | 13,192,335.7 | 16,078,130.7 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 13,735,270.2 | 16,863,795.4 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (542,934.5) | (785,664.6) |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 296,808.9 | 646,035.4 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 1,146,488.8 | 1,764,981.6 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,812,025.7** | **25,871,087.9** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,812,025.7 | 25,871,087.9 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **3,909,386.3** | **13,716,481.2** |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 17,455,802.0 | 37,849,975.7 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 17,455,802.0 | 37,849,975.7 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 12,685,073.1 | 16,076,360.1 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 3,702,937.3 | 4,292,653.3 |

| | | | |
|---|---|---|---|
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 600,479.9 | 814,427.2 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 3,936,331.8 | 3,923,414.5 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 355,271.6 | 517,669.6 |
| 2105 | Нормативт зардал | 272,738.6 | 236,346.2 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 430,788.8 | 260,771.4 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 35,461.2 | 59,111.2 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 534,065.7 | 1,113,770.2 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,816,998.3 | 4,858,196.4 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 4,770,728.9 | 19,025,659.0 |
| 22 | Хөрөнгийн зардал | | 2,747,956.6 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 2,901,243.4 | 6,510,260.0 |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **4,399,618.2** | **1,347,533.5** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **(1,498,374.8)** | **5,162,726.5** |

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (мянган төгрөг)

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

| **Код** | **Тайлангийн үзүүлэлт** | **Засгийн газрын хувь оролцооны нийт дүн** | **Нийт цэвэр хөрөнгө/өмч** |
|---|---|---|---|
| 1 | 2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 16,845,259.0 | 16,845,259.0 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 220,263.4 | 220,263.4 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 17,065,522.4 | 17,065,522.4 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | (185,293.2) | (185,293.2) |
| 5 | Тайлант үеийн үр дүн | (1,498,374.8) | (1,498,374.8) |
| **6** | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **15,381,854.4** | **15,381,854.4** |
| 7 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | (419.9) | (419.9) |
| 8 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 15,381,434.5 | 15,381,434.5 |
| 9 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | (11,411.1) | (11,411.1) |
| 10 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | | - |
| 11 | Тайлант үеийн үр дүн | 5,162,726.4 | 5,162,726.4 |
| 12 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **20,532,749.8** | **20,532,749.8** |

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан (мянган төгрөг)

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

| **Код** | **Тайлангийн үзүүлэлт** | **2024 оны 12-р сарын 31** | **2025 оны 12-р сарын 31** |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **20,261,575.3** | **24,848,729.4** |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 14,636,547.6 | 18,489,147.7 |
| 110 | Орлогын албан татвар | 13,192,335.7 | 16,078,130.7 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 13,735,270.2 | 16,863,795.4 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (542,934.5) | (785,664.6) |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 297,723.1 | 646,035.4 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 1,146,488.8 | 1,764,981.6 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 362,299.3 | 474,134.9 |
| 1181 | Газрын төлбөр | 780,986.0 | 1,287,764.1 |

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | |
|---|---|---|---|
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 3,203.4 | 3,082.7 |
| 1183 | Бусад татвар | - | |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 699,894.9 | 714,332.4 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 699,894.9 | 714,332.4 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 4,925,132.8 | 5,645,249.2 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **16,405,436.2** | **20,068,778.6** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 16,405,436.2 | 20,068,778.6 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 10,627,166.6 | 10,940,352.5 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2,777,203.3 | 3,259,315.2 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 512,013.1 | 625,004.8 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 3,982,873.1 | 3,321,875.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 289,941.8 | 369,135.6 |
| 2105 | Норматив зардал | 506.3 | - |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 411,432.5 | 236,499.9 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 31,161.2 | 229,297.9 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 572,253.8 | 1,055,447.4 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,049,781.6 | 1,996,414.1 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 5,778,269.6 | 9,128,426.1 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **3,856,139.1** | **4,779,950.7** |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 3,182,705.4 | 2,935,666.2 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 3,182,705.4 | 2,935,666.2 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 3,182,705.4 | 2,935,666.2 |
| 2260 | Гадаад эх үүсвэрээр | - | |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(3,182,705.4)** | **(2,935,666.2)** |
| **VII** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН** | **(101,847.9)** | **(347,000.0)** |
| 14 | Бусад эх үүсвэр | - | |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 101,847.9 | (347,000.0) |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **571,585.9** | **1,497,284.6** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 740,523.2 | 1,305,393.4 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 1,305,393.4 | 2,802,678.0 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөг)**

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

| Дансны код | Дансны нэр, төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хэтрэлт, хэмнэлт | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **1** | **НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | **23,433,490.2** | **23,155,304.7** | **32,209,273.3** | **98.8** |
| **11** | **Татварын орлого** | **17,585,839.7** | **18,489,147.7** | **17,585,839.7** | **105.1** |
| 110 | Орлогын албан татвар | 15,265,839.7 | 16,078,130.7 | 15,265,839.7 | 105.3 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 16,051,484.3 | 16,863,795.4 | 16,051,484.3 | 105.1 |
| 110001 | Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого | 14,094,484.3 | 14,878,950.2 | 14,094,484.3 | 105.6 |
| 110002 | Үйл ажиллагааны орлого | 347,000.0 | 347,368.6 | 347,000.0 | 100.1 |
| 110003 | Хөрөнгийн орлого | 750,000.0 | 759,749.7 | 750,000.0 | 101.3 |
| 110004 | Хөрөнгө борлуулсны орлого | 380,000.0 | 387,817.7 | 380,000.0 | 102.1 |
| 110008 | Шууд бус орлого | 480,000.0 | 489,909.1 | 480,000.0 | 102.1 |

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (785,644.6) | (785,664.6) | (785,644.6) | 100.0 |
| 110101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (785,644.6) | (785,664.6) | (785,644.6) | 100.0 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 577,000.0 | 646,035.4 | 577,000.0 | 112.0 |
| 113001 | Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар | 540,000.0 | 573,052.6 | 540,000.0 | 106.1 |
| 113002 | Бууны албан татвар | 11,000.0 | 13,521.0 | 11,000.0 | 122.9 |
| 113004 | Малд ногдуулах албан татвар | 26,000.0 | 59,461.8 | 26,000.0 | 228.7 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 1,743,000.0 | 1,764,981.6 | 1,743,000.0 | 101.3 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 456,000.0 | 474,134.9 | 456,000.0 | 104.0 |
| 118001 | Улсын тэмдэгтийн хураамж | 123,000.0 | 123,084.8 | 123,000.0 | 100.1 |
| 118006 | Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | 43,000.0 | 43,565.7 | 43,000.0 | 101.3 |
| 118009 | Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 290,000.0 | 307,484.4 | 290,000.0 | 106.0 |
| 1181 | Газрын төлбөр | 1,287,000.0 | 1,287,764.1 | 1,287,000.0 | 100.1 |
| 118101 | Газрын төлбөр | 1,287,000.0 | 1,287,764.1 | 1,287,000.0 | 100.1 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | - | 3,082.7 | - | - |
| 118202 | Ан амьтны нөөц ашигласны төлбөр | - | 434.0 | - | - |
| 118203 | Ус, рашааны нөөц ашигласны төлбөр | - | 2,648.7 | - | - |
| **12** | **Татварын бус орлого** | **5,847,650.5** | **4,666,157.0** | **14,623,433.6** | **79.8** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 420,000.0 | 682,685.7 | 422,000.0 | 162.5 |
| 120003 | Торгуулийн орлого | 420,000.0 | 422,606.9 | 420,000.0 | 100.6 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/ | - | 252,250.1 | 2,000.0 | - |
| 120009 | Бусад орлого | - | 7,828.7 | - | - |
| 122 | Тусламжийн орлого | 5,427,650.5 | 3,983,471.3 | 10,177,725.2 | 73.4 |
| 122005 | Төсвөөс санхүүжих | - | - | 10,177,725.2 | - |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 4,023,708.4 | 3,983,471.3 | 4,023,708.4 | 99.0 |
| 123002 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого | 4,023,708.4 | 3,983,471.3 | 4,023,708.4 | 99.0 |
| | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 1,403,942.1 | - | - | - |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **23,433,490.2** | **21,677,167.9** | **-** | **92.5** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **9,735,541.4** | **28,091,365.0** | **14,879,033.6** | **288.5** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **9,555,701.4** | **9,419,768.7** | **10,153,725.2** | **98.6** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,857,024.6 | 1,885,972.3 | 9,973,885.2 | 101.6 |
| 210101 | Үндсэн цалин | 802,785.4 | 1,100,686.3 | 1,857,024.6 | 137.1 |
| 210102 | Нэмэгдэл | 767,927.7 | 488,014.8 | 802,785.4 | 63.5 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 145,697.1 | 767,927.7 | - |
| 210104 | Урамшуулал | 154,911.5 | 108,557.1 | - | 70.1 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 131,400.0 | 43,017.0 | 154,911.5 | 32.7 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 270,376.1 | 270,169.4 | 131,400.0 | 99.9 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 200,509.3 | 200,448.7 | 270,376.1 | 100.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 17,466.7 | 17,442.3 | 200,509.3 | 99.9 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,733.4 | 8,730.6 | 17,466.7 | 100.0 |

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 8,733.4 | 8,730.6 | 8,733.4 | 100.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 34,933.3 | 34,817.1 | 8,733.4 | 99.7 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 3,353,996.2 | 3,305,008.0 | 34,933.3 | 98.5 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 254,528.7 | 244,705.9 | 3,772,180.0 | 96.1 |
| 210302 | Түлш, халаалт | 2,512,069.1 | 2,505,431.8 | 262,678.7 | 99.7 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 587,398.4 | 554,870.3 | 2,908,102.9 | 94.5 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 61,708.4 | 53,754.4 | 601,398.4 | 87.1 |
| 210401 | Бичиг хэрэг | 12,037.0 | 9,059.7 | 61,708.4 | 75.3 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 27,936.8 | 27,071.8 | 12,037.0 | 96.9 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 14,405.1 | 10,099.0 | 27,936.8 | 70.1 |
| 210404 | Ном, хэвлэл | 220.0 | 220.0 | 14,405.1 | 100.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,110.0 | 990.0 | 220.0 | 89.2 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,999.5 | 6,314.0 | 1,110.0 | 105.2 |
| 2105 | Нормативт зардал | 1,600.0 | - | 5,999.5 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,600.0 | - | 1,600.0 | - |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 295,312.9 | 282,536.7 | 1,600.0 | 95.7 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 55,337.9 | 30,338.8 | 295,312.9 | 54.8 |
| 210602 | Тавилга | 3,100.0 | 22,900.0 | 55,337.9 | 738.7 |
| 210604 | Урсгал засвар | 236,875.0 | 229,297.9 | 3,100.0 | 96.8 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 56,961.0 | 56,519.2 | 236,875.0 | 99.2 |
| 210701 | Гадаад албан томилолт | 19,500.0 | 19,500.0 | 56,961.0 | 100.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 37,461.0 | 37,019.2 | 19,500.0 | 98.8 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 949,152.4 | 888,725.5 | 37,461.0 | 93.6 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 943,539.3 | 883,112.4 | 949,152.4 | 93.6 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 426.7 | 426.7 | 943,539.3 | 100.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 138.0 | 138.0 | 426.7 | 100.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 66.0 | 66.0 | 138.0 | 100.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,982.4 | 2,982.4 | 66.0 | 100.0 |
| 210807 | Газрын төлбөр | 2,000.0 | 2,000.0 | 2,982.4 | 100.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,709,569.8 | 2,677,083.1 | 2,000.0 | 98.8 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,691,367.8 | 2,666,955.6 | 2,709,569.8 | 99.1 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 18,202.0 | 10,127.5 | 2,691,367.8 | 55.6 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **9,152,480.4** | **9,112,788.0** | **18,202.0** | **99.6** |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 8,972,640.4 | 8,987,139.8 | 179,840.0 | 100.2 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 8,972,640.4 | 8,987,139.8 | 30,500.0 | 100.2 |
| 213103 | Төсвийн санхүүжилт | - | - | 30,500.0 | #DIV/0! |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 149,340.0 | 125,648.2 | - | 84.1 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 45,000.0 | 43,740.0 | 149,340.0 | 97.2 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 77,000.0 | 64,348.2 | 45,000.0 | 83.6 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 27,340.0 | 17,560.0 | 77,000.0 | 64.2 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **4,177,308.4** | **2,797,611.2** | **27,340.0** | **67.0** |
| 223001 | Бусад хөрөнгө | 4,177,308.4 | 2,797,611.2 | 4,177,308.4 | 67.0 |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | **548,000.0** | **347,000.0** | **4,177,308.4** | **63.3** |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 548,000.0 | 347,000.0 | 548,000.0 | 63.3 |
| **8** | **ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ** | **-** | **1,478,136.8** | **548,000.0** | **-** |
| **9** | **АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **-** | **(1,478,136.8)** | **17,330,239.7** | **-** |
| 7 | Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | - | (1,478,136.8) | (17,330,239.7) | - |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 1,288,123.3 | (17,330,239.7) | - |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 2,771,967.4 | - | - |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөг)

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

| Дансны код | Дансны нэр, төрөл | Тайлант он |
|---|---|---|
| 1 | НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 125,189.4 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 125,189.4 |
| 122 | Тусламжийн орлого | 125,189.4 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | 125,189.4 |
| 12213 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 125,189.4 |
| 350011 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 45,000.0 |
| 350014 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 67,280.1 |
| 350015 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 12,909.3 |
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 85,325.1 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 85,325.1 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 85,325.1 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 63,660.5 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 63,660.5 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 21,664.6 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 21,664.6 |
| 4 | ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ | 39,864.3 |
| 5 | АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | (39,864.3) |
| 6 | Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | (39,864.3) |

# 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

## 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Есөнбулаг сумын Засаг дарга нь Монгол Улсын үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн чиг үүргийг хэрэгжүүлж, нутгийн өөрөө удирдах ёсны чадавхыг дээшлүүлэх, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх ойрын бодлогыг зөв зохистой тодорхойлох иргэдийн ашгийг хамгаалан, сайн сайхан амьдрах орчин бүрдүүлэх хүний хөгжлийг бүх талаар хангахад оршино гэсэн эрхэм зорилгыг тодорхойлсон байна.

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Бугат сумын Засаг дарга нь санхүүгийн үйл ажиллагаандаа Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажиллаж байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь Есөнбулаг сумын Засаг даргын санхүүгийн үйл ажиллагаа, Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийгээгүй байна.

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн яамнаас 2026 онд нэвтрүүлсэн finperform.gov.mn нэгдсэн системд нэгтгэсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Есөнбулаг сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, тусгай зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.
Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Есөнбулаг сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжсэн байгууллагын орон нутгаас баталсан төсвийн хүрээнд мөнгөн гүйлгээний тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг нэгтгэсэн байна.
Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,892.1 сая төгрөгөөр буюу 38.0 хувиар өссөн байна.

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

*Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт*

*(мянган төгрөг)*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| **Б** | **1** | **2** | **3=2-1** |
| Мөнгөн хөрөнгө | 1,305,393.4 | 2,802,678.0 | 1,497,284.6 |
| Авлага | 1,288,161.6 | 1,171,342.0 | (116,819.6) |
| Урьдчилгаа | 1,864.2 | 37.4 | (1,826.8) |
| Бараа материал | 374,551.4 | 279,903.1 | (94,648.3) |
| Бусад эргэлтийн хөрөнгө | 44,596.0 | 81,952.0 | 37,356.0 |
| Нөөцийн бараа | 1,554,895.3 | 1,661,726.0 | 106,830.7 |
| Үндсэн хөрөнгө | 11,132,550.4 | 15,596,457.8 | 4,463,907.4 |
| Нийт хөрөнгө | **15,702,012.3** | **21,594,096.3** | **5,892,084.0** |
| Өр төлбөр | 320,157.9 | 1,061,226.5 | 741,068.6 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 15,381,854.4 | 20,532,869.8 | 5,151,015.4 |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | **15,702,012.3** | **21,594,096.3** | **5,892,084.0** |

*Эх сурвалж: Есөнбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл*

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, бусад эргэлтийн хөрөнгө, үндсэн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчийн данс байна.

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 2,802.7 сая төгрөг болж, өмнөх оноос 1,497.3 сая төгрөгөөр өссөн.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос өссөн нь орон нутгийн орлого давсан, ОНХС-гийн өмнөх оны ажлын гүйцэтгэлийг санхүүжүүлсэн холбоотой байна.

*Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл*

*(мянган төгрөг)*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| **Банканд байгаа бэлэн мөнгө** | 1,305,393.4 | 2,802,678.0 | 1,497,284.6 |
| **Төгрөг** | 1,305,393.4 | 2,802,678.0 | 1,497,284.6 |
| **Төрийн сангийн харилцах** | 1,297,657.6 | 2,800,841.7 | 1,503,184.1 |
| **Арилжааны банк дахь харилцах** | 7,735.8 | 1,836.3 | (5,899.6) |
| **Дүн** | **1,305,393.4** | **2,802,678.0** | **1,497,284.6** |

*Эх сурвалж: Есөнбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл*

Тайлант оны мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 99.9 хувь буюу 2,800.8 сая төгрөг нь төрийн сангийн харилцах дансанд, 0.1 хувь буюу 1.8 сая төгрөг нь арилжааны банк дахь харилцах дансанд байршиж байгаа Алтай хотын тохижилт үйлчилгээний газар, Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл байна.

### 3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 1,171.3 сая төгрөг болж, өмнөх оноос 116.8 сая төгрөгөөр буурсан байна.

Есөнбулаг сумын ЗДТГ-ын байгууллагаас авах 81.1 сая төгрөгөөр тус тус буурсантай холбоотой.

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

*Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл*

(мянган төгрөг)

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Ажиллагчтай холбогдсон авлага | 25,087.5 | 24,039.3 | (1,048.2) |
| Татаас, санхүүжилтийн авлага | 104,401.9 | 15,786.6 | (88,615.3) |
| Зээлийн хүүгийн авлага | 46,310.1 | 40,999.4 | (5,310.7) |
| Байгууллагаас авах авлага | 260,266.7 | 137,790.8 | (122,475.9) |
| Хувь хүмүүсээс авах авлага | 150,570.2 | 127,639.7 | (22,930.5) |
| Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага | 701,525.2 | 825,086.1 | 123,560.9 |
| Дүн | **1,288,161.6** | **1,171,342.0** | **(116,819.6)** |

*Эх сурвалж: Есөнбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл*

Авлага дансны үлдэгдлийн 70.0 хувь буюу 825.1 сая төгрөг нь ХХС-гийн авлага, 30.0 хувь буюу 346.2 сая төгрөг нь төсөвт байгууллагуудын авлага эзэлж байна.

### 3.4.3 Урьдчилж гарсан зардал

*Хүснэгт 4. Урьдчилж гарсан зардлын тооцоо*

(мянган төгрөг)

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3 |
| Урьдчилж гарсан зардал | 1,864.2 | 37.4 | (1,826.8) |
| дүн | **1,864.2** | **37.4** | **(1,826.8)** |

*Эх сурвалж: Есөнбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл*

Оны эхэнд Марал-алтай өрхийн эрүүл мэндийн төв нь цалингийн урьдчилгаа 1.8 сая төгрөгийн урьдчилгааг суутган тооцсон байна.

### 3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 361.8 сая төгрөг болж, өмнөх оноос 57.3 сая төгрөгөөр буурсан нь төсөвт байгууллагуудын бусад хангамжийн материалын зарцуулалт нэмэгдсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл*

(мянган төгрөг)

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1.0 | 2.0 | 3.0 |
| Түүхий эд материал | **50,946.4** | **43,695.3** | **(7,251.1)** |
| Тусгай зориулалттай материал | 8,096.7 | 7,901.1 | **(195.6)** |
| Эм боох материал | 42,849.7 | 35,794.2 | **(7,055.5)** |
| Хангамжийн материал | **276,305.0** | **188,907.8** | **(87,397.2)** |
| Бичиг хэргийн материал | 11,389.0 | 10,420.8 | **(968.2)** |
| Аж ахуйн материал | 134,337.3 | 140,083.2 | **5,745.9** |
| Сэлбэг хэрэгсэл | 28,226.8 | 24,716.8 | **(3,510.0)** |
| Түлш, шатах тослох материал | 1,023.0 | 720.0 | **(303.0)** |
| Барилгын засварын материал | 7,330.0 | 7,330.0 | - |
| Хүнсний материал | 313.8 | - | **(313.8)** |
| Бусад хангамжийн материал | 93,685.0 | 5,637.0 | **(88,048.0)** |

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | |
|---|---|---|---|
| Мал амьтад | 47,300.0 | 47,300.0 | - |
| **НӨӨЦИЙН БАРАА** | **44,596.0** | **81,952.0** | **37,356.0** |
| Дүн | **419,147.4** | **361,855.1** | **(57,292.3)** |

*Эх сурвалж: Есөнбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл*

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 648.2 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, 109.4 сая төгрөгийг үнэ төлбөргүйгээр бүртгэж, 717.7 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, 97.1 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлэн бүртгэсэн байна.

### 3.4.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 1,661.7 сая төгрөг болж, 106.8 сая төгрөгөөр өссөн нь өмнөх оны ОНХС-гийн хэрэгжиж дуусаагүй төсөл арга хэмжээг тус дансанд бүртгэсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 7. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл*

*(мянган төгрөг)*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| **БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ** | **1,554,895.3** | **1,661,726.0** | **106,830.7** |
| **Дүн** | **1,554,895.3** | **1,661,726.0** | **106,830.7** |

*Эх сурвалж: Есөнбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл*

### 3.4.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 15,596.5 сая төгрөг болж, өмнөх оноос 4,463.9 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл*

*(мянган төгрөг)*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1.0 | 2.0 | 3.0 |
| **Биет хөрөнгө** | **10,786,561.0** | **15,255,086.8** | **4,468,525.8** |
| Барилга, байгууламж, орон сууц | 1,885,359.4 | 1,981,317.6 | 95,958.2 |
| Авто-тээврийн хэрэгсэл | 1,162,165.0 | 963,372.9 | (198,792.2) |
| Машин тоног төхөөрөмж(компьютер) | 772,379.0 | 590,947.6 | (181,431.4) |
| Тавилга, аж ахуйн эд хогшил | 78,417.8 | 104,640.3 | 26,222.5 |
| Зам, гүүрний байгууламж | 4,736,493.4 | 4,294,422.5 | (442,070.9) |
| Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 10,000.0 | 10,000.0 | - |
| Бусад үндсэн хөрөнгө | 2,141,746.2 | 7,310,385.8 | 5,168,639.6 |
| **Биет бус хөрөнгө** | **345,989.4** | **341,371.1** | **(4,618.3)** |
| Программ хангамж | 4,203.8 | 4,166.3 | (37.5) |
| Бусад биет бус хөрөнгө | 341,785.7 | 337,204.8 | (4,580.8) |
| **Дүн** | **11,132,550.4** | **15,596,457.8** | **4,463,907.5** |

*Эх сурвалж: Есөнбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл*

Нийт хөрөнгийн 97.0 хувийг биет хөрөнгө, 3.0 хувийг биет бус хөрөнгө эзэлж байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 138.0 сая төгрөгийн, хандиваар 91.3 сая төгрөгийн, шилжүүлэн авсан 510.0 сая төгрөгийн хөрөнгө, бусад эх үүсвэрээс 6,727.8 сая төгрөгийн, үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлээр 505.0 сая төгрөгийн, нийт 7,972.3 сая

төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолын дагуу 718.2 сая төгрөгийн хөрөнгийг акталж устгаж, 893.4 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн бүртгэж, 51.5 сая төгрөгийн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн, 543.0 сая төгрөгийн шилжүүлэн, 1,170.9 сая төгрөгийн хөрөнгийг дахин үнэлгээний хорогдлоор бүртгэсэн байна.

### 3.4.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 1,061.2 сая төгрөг болж, өмнөх оноос 741.1 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 9. Нийт өр төлбөрийн үлдэгдэл*

*( мянган төгрөг)*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1.0 | 2.0 | 3.0 |
| Ажилчидтай холбогдсон өглөг | 26,657.1 | 158,611.8 | 131,954.7 |
| Бараа үйлчилгээний зардлын өглөг | 6,986.9 | 24,354.8 | 17,367.9 |
| Байгууллагад төлөх өглөг | 211,461.1 | 803,937.8 | 592,476.7 |
| Хувь хүмүүст төлөх өглөг | 75,052.8 | 74,322.0 | (730.8) |
| **Дүн** | **320,157.9** | **1,061,226.5** | **741,068.6** |

*Эх сурвалж: Есөнбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл*

Нийт өр төлбөрийн 741.1 сая төгрөгөөр өссөн нь Есөнбулаг сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн түлш халаалтын зардлын 633.9 сая төгрөгийн өр төлбөр нэмж үүссэнтэй холбоотой байна.

### 3.4.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 20,532.8 сая төгрөг болж, өмнөх оноос 5,151.0 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 10. Засгийн газрын хувь оролцоо*

*(мянган төгрөгөөр)*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3 |
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 5,003,083.5 | 5,003,083.5 | - |
| Хуримтлагдсан үр дүн | **8,302,379.0** | **13,464,805.6** | **5,162,426.5** |
| Өмнөх үеийн үр дүн | 8,860,606.5 | 8,322,676.3 | (537,930.1) |
| Тайлант үеийн үр дүн | (558,227.4) | 5,142,129.3 | 5,700,356.7 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,076,391.9 | 2,064,980.8 | (11,411.1) |
| **Дүн** | **15,381,854.4** | **20,532,869.8** | **5,151,015.4** |

*Эх сурвалж: Есөнбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл*

Өмнөх үеийн үр дүн 537.9 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнгээс шалтгаалсан байна.

### 3.4.8 Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Есөнбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн “Сумын 2025 оны төсвийн тодотгол батлах тухай” 13 дугаар тогтоолд Есөнбулаг сумын Засаг дарга нь 17,585.8 сая төгрөгийн татварын, 420.0 сая төгрөгийн татварын бус, нийт 18,005.8 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдаж, гүйцэтгэлээр 18,919.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөө 103.0 хувиар биелүүлсэн байна.

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Орон нутгийн тасарсан орлого байхгүй, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дээрх тогтоолоор тодотгон баталсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн захирагч төсвийн төсөлд орон нутгийн байгууллагуудын зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 20,826.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Есөнбулаг сумын Засаг дарга 2025 онд төсөвт байгууллагуудын урсгал үйл ажиллагааны санхүүжилтийг 13,463.5 сая төгрөг, ОНХС-гийн төсвийг 7,012.5 сая төгрөгөөр, ХХС-гийн төсвийг 350.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсөв захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн саналыг 2,607.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн нийт зардал ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 23,433.5 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь ЗДТГ, ОНХС-гийн санхүүжилт нэмэгдсэнтэй холбоотой байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 13 дугаар тогтоолоор төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 23,433.5 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 9,735.6 сая төгрөгийг урсгал зардалд, 4,177.3 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 548.0 сая төгрөгийг эргэж төлөгдөх зээлд, 8,972.6 сая төгрөгийн аймгийн төсөвт төвлөрүүлэхээр баталсан байна.

Нийт эх үүсвэрийн 18,005.8 сая төгрөгийн татварын болон татварын бус орлогоос, 4,023.7 сая төгрөгийг ОНХС-гаас, 1,404.0 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс, нийт 23,433.5 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Тайлант онд төсөвт байгууллагуудад олгосон илүү, дутуу санхүүжилт байхгүй.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 21,677.2 сая төгрөг буюу 93.0 хувьтай байгаа нь ОНХС-гийн хөрөнгийг 1,379.7 сая төгрөгөөр төлөвлөснөөс дутуу зарцуулж, ХХС-гаас 201.9 сая төгрөгийн төлөвлөсөн зээлийг олгоогүй зэрэг голлон нөлөөлсөн байна.

*Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

*(мянган төгрөгөөр)*

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| 1 | 70105 ОН-ын өөрөө удирд ёсны байгуул | 452.2 | 428.5 | (23.6) |
| 2 | 70106 ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага | 5,881.5 | 5,780.9 | (100.5) |
| 3 | 70501 ОН-ын төсөвт олгох Шилжүүлэг | 8,972.8 | 8,972.8 | 0.0 |
| 4 | 70503 Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт | 4,177.3 | 2,797.6 | (1,379.7) |
| 5 | 71801 Сургуулийн өмнөх боловсрол | 903.5 | 852.9 | (50.6) |
| 6 | 71802 Ерөнхий боловсрол | 2,496.2 | 2,496.2 | 0.0 |
| 7 | 72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих | 550.0 | 348.1 | (201.9) |
| | **Нийт** | **23,433.5** | **21,677.2** | **(1,756.3)** |

*Эх сурвалж: Есөнбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл*

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Орон нутгийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилтийн талаарх мэдээллийг дэлгэрэнгүй тайлагнасан болно.

Тайлант онд үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 57,909.3 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 67,280.1 мянган төгрөгийн нийт 125,189.4 мянган төгрөгийг эх үүсвэрийг авч, 85,325.1 мянган төгрөгийг зарцуулж, 39,864.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Есөнбулаг сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2026 оны 3 дугаар сарын 20-ны өдрөөс 2026 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн хооронд ахлах аудитор Д.Цэрэнханд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Г.Гүнжидмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Есөнбулаг сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 1/45 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсөв 23,433.5 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 351.5 сая төгрөгөөр тогтоосныг дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллах үүрэгтэй. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас сумын Засаг даргын захирамжаар дараах үйл ажиллагааг санхүүжүүлсэн байна. Үүнд:

- Бараа үйлчилгээний бусад зардал, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас сар шинийн золголтод 10.3 сая төгрөг, уралдаан тэмцээний бай шагналд 33.9 сая төгрөг, бэлэг дурсгалын зүйлд 21.9 сая төгрөг, Төсөвт байгууллагуудад 22.0 сая төгрөгийн дэмжлэг, аймгийн өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 3.0 сая төгрөгийн дэмжлэг, зорилтот бүлгийн иргэдэд нүүрсний дэмжлэг олгоход 9.5 сая төгрөг, өдөр өнжүүлэх төвд 10.0 сая төгрөг, сургалт туршлага судлах мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэхэд 29.1 сая төгрөг, контент бичлэг хийхэд 3.6 сая төгрөг гэх мэт үр ашиггүй тэвчиж болох зардлыг санхүүжүүлсэн,
- Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас Спортын арга хэмжээний хувцас бэлтгэхэд 4.6 сая мянган төгрөгийн хөрөнгө зарцуулсан,
- Залуу малчин өрхийг малжуулах хөтөлбөрийн хүрээнд 3 өрхөд 12.0 сая төгрөгийн малжуулалт хийхдээ буцаан авах нөхцөлгүй олгосон ба хөрөнгө хүлээлцсэн акт байхгүй, анхан шатны баримт дутуу зарцуулсан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасны дагуу Есөнбулаг сумын Засаг даргын 2025 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

Тус сумын ХХС-гийн аудитаар нийцлийн асуудалтай холбоотой 25.4 сая төгрөгийн 1 албан шаардлагыг хүргүүлсэн байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Есөнбулаг сумын Засаг дарга Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих мэдээллийг бүрэн мэдээлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байна гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Харьяа байгууллагууд хийсэн аудитаар илэрсэн нийцлийн асуудлын талаар:

Аудитаар нийт ЗДТГ-т шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 зөрчил илэрсэнд зөвлөмж хүргүүлсэн байна.

### 4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Есөнбулаг сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар 28.1 сая төгрөгийн 2 зөрчил арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн байна.

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудитын шийдвэрийг хэрэгжүүлэн ажилласан боловч харьяа нэг байгууллагуудын шийдвэрийг хэрэгжүүлэх 1 албан шаардлага дутуу хэрэгсэн байна.

*Хүснэгт 12. Албан шаардлагын хэрэгжилт*

*(мянган төгрөгөөр)*

| Үзүүлэлт | Илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 2 | 28,165.7 | 1 | 28,165.7 | 1 | - | 100.0 |
| **Нийт дүн** | **2** | **28,165.7** | **1** | **28,165.7** | **1** | **-** | **100.0** |

### 4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

- Дараагийн аудитаар орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлт, авлага өр төлбөрийн барагдуулалтыг авч үзэх нь зүйтэй.

## 5.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

**5.1** Аудитаар нийт 24,744.6 сая төгрөгийн 4 алдаа илрүүлснийг аудитын явцад залруулсан байна.
Залруулсан алдаа

**Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:**

- БХНСС-гийн данснаас 6,000.0 мянган төгрөгийг зарцуулсныг өмнөх оны СТА-аар төлбөрийн акт тогтоож төлүүлсэн орлогыг байгууллагад төлөх өглөгөөр тусгаагүй,
- Есөнбулаг сумын 7 дугаар цэцэрлэгийн тогтмол зардлын батлагдсан төлөвлөгөөг 6,250.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан,
- Сумын ЗДТГ-ын санхүүжилт 11,580.4 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан,
- Малын тоо толгойн орлогыг 914.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

### 5.1.1 Харьяа байгууллагууд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 20 байгууллагын (Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Өрхийн Эрүүл мэндийн төв) тогтмол зардал, 3 тусгай сан, 1 ААТҮГ, 1 төрийн сангийн санхүүгийн тайлан, нийт 27 тайлан нэгтгэснээс 20 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 тусгай сан, 3 өрхийн эрүүл мэндийн төвийг түүвэрт хамруулсан.

Аудитаар дүгнэлт гаргасан 20 байгууллагаас сумын ЗДТГ, ИТХ, Алтай хотын тохижилт үйлчилгээний газар зэрэг 3 байгууллага "Хязгаарлалттай", ерөнхий боловсролын 5 сургууль, хүүхдийн 12 цэцэрлэгт "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн байна.

### 5.1.2 Түүвэрт хамрагдсан Хоршоо хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан, Орон нутгийн хөгжлийн сан, өрхийн Эрүүл мэндийн төвүүдийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил

Аудитаар санхүүгийн тайлангийн бүртгэл, тайлагналыг 4,416.5 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 9 алдааг залруулж, 1.0 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 1,525.6 сая төгрөгийн 3 зөрчлийг арилгах албан шаардлага, 15.5 сая төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлсэн байна.



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**5.1.3 Аудитаар Засаг даргын Тамгын газар, иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Алтай хотын тохижилт үйлчилгээний газрын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил**

Дүгнэлт гаргасан байгууллагуудын санхүүгийн тайлангийн бүртгэл, тайлагналыг 154.9 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 7 алдааг залруулж, 7.5 сая төгрөгийн 4 төлбөрийн акт тогтоож, 8.7 сая төгрөгийн 2 зөрчлийг арилгах албан шаардлага, 283.6 сая төгрөгийн 9 зөвлөмж, 252.4 сая төгрөгийн зөрчилд 4 албан тушаалтанд сахилгын хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн байна.

**5.2 Төсвийн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт**

Залруулагдаагүй нийт 394.0 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшин их бөгөөд харьяа байгууллагуудын материаллаг зөрчил 2,069.4 сая байгаа тул шинж чанарыг харгалзан үзэж "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 394.0 сая төгрөгийн 7 зөрчил илрүүлснээс, 58.5 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 1 зөрчлийг давтан гаргахгүй байх 1, сахилгын хариуцлага тооцуулах тухай 1 албан шаардлага, 335.5 сая төгрөгийн 4 зөвлөмжийг хүргүүлсэн.

**5.3 Төлбөрийн акт**

1. Малын тоо, толгойн албан татварын орлого 58.5 сая төгрөгийг ОНХС-д төвлөрүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх"; 60 дугаар зүйлийн 60.2.8-д "Малын тоо толгойн албан татварын орлого. Уг орлогын эх үүсвэрийг бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулна." гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Дутуу төвлөрүүлсэн 39.2 сая төгрөгийг Тонхил сумын Төрийн сан дахь Га.Есөнбулаг ОНХС 100050152400 тоот дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт хүргүүлсэн.

**5.4 Албан шаардлага**

1. Төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2,069.4 сая төгрөгийн зөрчил илэрснээс 8.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх 1,508.9 сая төгрөгийн 4 албан шаардлага, 299.5 сая төгрөгийн 12 зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлж, 252.4 сая төгрөгийг зөрчилд 4 албан тушаалтанд сахилгын хариуцлага тооцох албан шаардлагыг хүргүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах"; 14.2.5-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах"; 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.6-т "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд тавих санхүүгийн дотоод хяналтыг сайжруулж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

2. Есөнбулаг сумын Засаг даргад 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар өгсөн 01/174 дугаартай 1 албан шаардлага, 2022-2025 оны гүйцэтгэл, нийцлийн аудитаар өгсөн 438.5 сая төгрөгийн 11 албан шаардлагын биелэлтийг ирүүлээгүй, хэрэгжүүлэх арга хэмжээг авч ажиллаагүй нь Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13-т "албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтын 19 дүгээр зүйлийн 19.2-т "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. байна.

Шийдвэрлэсэн нь: Есөнбулаг сумын Засаг дарга Н.Золжаргалд хуульд заасны дагуу сахилгын хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

**5.5 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. ***Засаг даргын нөөц хөрөнгөний зарцуулалттай холбоотой асуудал***

*Илрүүлэлт:*

**Нэг.** Сумын Засаг даргын захирамжаар бараа үйлчилгээний бусад зардал, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас сар шинийн золголтод 10.3 сая төгрөг, уралдаан тэмцээний бай шагналд 33.9 сая төгрөг, бэлэг дурсгалын зүйлд 21.9 сая төгрөг, Төсөвт байгууллагуудад 22.0 сая төгрөгийн дэмжлэг, аймгийн өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 3.0 сая төгрөгийн дэмжлэг, зорилтот бүлгийн иргэдэд нүүрсний дэмжлэг олгоход 9.5 сая төгрөг, өдөр өнжүүлэх төвд 10.0 сая төгрөг, сургалт туршлага судлах мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэхэд 29.1 сая төгрөг, контент бичлэг хийхэд 3.6 сая төгрөг гэх мэт үр ашиггүй тэвчиж болох зардлыг санхүүжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т “хуулиар зөвшөөрөөгүй бусад”, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал хавсралт "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1-т "Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна" гэж заасантай нийцэхгүй, хуваарилалт, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байх.

**Хоёр**. Сумын Засаг даргын захирамжаар бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас Спортын арга хэмжээний хувцас бэлтгэхэд 4.6 сая мянган төгрөгийн хөрөнгө зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т "Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн



ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно", 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад"Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал хавсралт "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1-т "Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна" гэж заасантай нийцэхгүй, хуваарилалт, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>Өгсөн зөвлөмж</u>: Төсвөөс хувцас хэрэгслийн болон зориулалт бус зардал гаргахгүй байх.

**Гурав.** Сумын Засаг даргын захирамжаар залуу малчин өрхийг малжуулах хөтөлбөрийн хүрээнд 3 өрхөд 12.0 сая төгрөгийн малжуулалт хийхдээ буцаан авах нөхцөлгүй олгосон ба хөрөнгө хүлээлцсэн акт байхгүй, анхан шатны баримт дутуу зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т “хуулиар зөвшөөрөөгүй бусад”, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал хавсралт "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1-т "Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна" гэж заасантай нийцэхгүй, хуваарилалт, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>Өгсөн зөвлөмж</u>: Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байх.

**Дөрөв.** Сумын орон нутгийн төсвөөс засаг Даргын Тамгын газарт 92.6 сая төгрөгийг илүү, Иргэдийн төлөөлөгчдийн хуралд 82.8 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох"; 14.2.5-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах"; 41 дүгээр зүйлийн 41.1-т "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.5-т "энэ хуулийн 37.1.8-д заасан эрхийн хүрээнд төсвийн байгууллагын зардлыг санхүүжүүлэх;" Есөнбулаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 13 дугаар тогтоол”-той нийцэхгүй, хуваарилалт, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>Өгсөн зөвлөмж</u>: Батлагдсан төсвийн хуваарийн дагуу нэгж байгууллагуудад санхүүжилтийг олгож байх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### *6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл*

***(мянган төгрөг)***

| Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Есөнбулаг сумын Засаг дарга | 4 | 3,241,571.1 | | | 4 | 3,241,571.1 | 4 | **3,241,571.1** | - | - | - | - |
| Есөнбулаг сумын ЗДТГ | 3 | 85,264.3 | 1 | 39,864.3 | 2 | 45,400.0 | 3 | 85,264.3 | - | - | - | - |
| Есөнбулаг сумын ИТХ | 3 | 14,607.7 | 1 | 12,064.0 | 2 | 2,543.7 | 3 | 14,607.7 | - | - | - | - |
| Есөнбулаг сумын ОНХС | 6 | 4,087,459.3 | | | 6 | 4,087,459.3 | 6 | 4,087,459.3 | - | - | - | - |
| Есөнбулаг сумын БХНСС | 1 | 13,340.0 | 1 | 13,340.0 | | | | | - | - | - | - |
| Есөнбулаг сумын ХХС | 2 | 314,224.5 | 1 | 85,015.5 | 1 | 229,209.0 | 2 | 235,414.0 | - | - | - | - |
| Алтай хотын тохижилт үйлчилгээний газар | 1 | 55,124.6 | | | 1 | 55,124.63 | 1 | 55,124.63 | - | - | - | - |
| Энх-Алтай ӨЭМТ | - | - | | | | | | | - | - | - | - |
| Жаргалан-Алтай ӨЭМТ | - | - | | | | | | | - | - | - | - |
| Марал-Алтай ӨЭМТ | 1 | 1,480.1 | | | 1 | 1,480.1 | 1 | 1,480.1 | - | - | - | - |
| Дүн | **21** | **7,813,071.6** | **4** | **150,283.8** | **17** | **7,662,787.8** | **20** | **7,720,921.1** | - | - | - | - |

### *6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл*

***(мянган төгрөг)***

| Байгууллагын нэр | Бүгд | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзах | Түүвэрт | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Есөнбулаг сумын Засаг дарга | 1 | - | 1 | - | - | - | 7 | 394,031.8 | **1** | **58,547.6** | 1 | - | 4 | 335,484.2 | 1.0 | | | |

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар

| | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Есөнбулаг сумын ЗДТГ | 1 | - | 1 | - | - | - | 6 | 387,153.3 | 2 | 6,441.5 | 1 | 4,727.5 | 1 | 128,041.6 | 2.0 | 247,942.7 | | |
| Есөнбулаг сумын ИТХ | 1 | - | 1 | - | - | - | 8 | 38,813.4 | 2 | 1,044.2 | | | 4 | 33,269.2 | 2.0 | 4,500.0 | - | - |
| Есөнбулаг сумын ОНХС | 1 | - | - | - | - | 1 | 3 | 1,435,614.9 | 1 | 1,000.0 | 1 | 1,431,979.3 | 1 | 2,635.6 | | | - | - |
| Есөнбулаг сумын БХНСС | 1 | - | - | - | - | 1 | - | - | | | | | | | | | - | - |
| Есөнбулаг сумын ХХС | 1 | - | - | - | - | 1 | - | - | | | | | | | | | - | - |
| Алтай хотын тохижилт үйлчилгээний газар | 1 | | 1 | | | | 5 | 126,268.3 | | | 1 | 4,000.0 | 4 | 122,268.3 | | | - | - |
| Энх-Алтай ӨЭМТ | 1 | - | - | - | - | 1 | 1 | 2,499.0 | | | | | 1 | 2,499.0 | | | - | - |
| Жаргалан-Алтай ӨЭМТ | 1 | - | - | - | - | 1 | 1 | 10,810.0 | | | | | 1 | 10,810.0 | | | - | - |
| Марал-Алтай ӨЭМТ | 1 | | - | - | - | 1 | 1 | 68,214.7 | | | 1 | 68,214.7 | | | | | - | - |
| **Дүн** | **10** | **-** | **4** | **-** | **-** | **6** | **32** | **2,463,405.4** | **6** | **67,033.3** | **5** | **1,508,921.5** | **16** | **635,007.9** | **5.0** | **252,442.7** | **-** | **-** |

***6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал*** ***(мянган төгрөг)***

| **Байгууллагын нэр** | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | **Төлбөрийн акт** | | **Албан шаардлага** | | **Зөвлөмж** | |
| | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** |
| Есөнбулаг сумын ХХС | **1** | 25,391.7 | | | **1** | 25,391.7 | - | - |
| **Дүн** | **1** | **25,391.7** | | | **1** | **25,391.7** | **-** | **-** |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР